



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2018 оны 07 сарын 30 өдөр

Дугаар А/482

Арвайхээр

Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот
үйлдвэрийн газруудын бүтэц, орон тоог батлах
тухай


Монгол Улсын “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль”-ийн 29 дүгээр зүйлийн 29.1.2 “в” дэх заалт, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн “Арвайхээр-тохижилт үйлчилгээ” орон нутгийн өмчит, аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар байгуулах тухай” 2014 оны 09, “Орон нутгийн өмчит, аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар байгуулах тухай” 2017 оны 52, “Орон нутгийн өмчит, аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар байгуулах тухай” 2017 оны 109 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Арвайхээр-тохижилт үйлчилгээний газар”, “Арвайхээр-Цэцэрлэгжилт” “Хужирт-тохижилт үйлчилгээний газар” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газруудын бүтэц, орон тоог хавсралтаар баталсугай.

2. Дээрх орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын үйл ажиллагаанд тогтмол хяналт тавьж ажиллахыг Арвайхээр сумын Засаг дарга (О.Пүрэвдорж), Хужирт сумын Засаг дарга (Р.Лхагвасүрэн) нарт үүрэг болгосугай.


3. Шинээр батлагдсан бүтэц, орон тоог 2018 оны 7 дугаар сарын 27-ны өдрөөс эхлэн мөрдөж ажиллахыг “Арвайхээр-тохижилт үйлчилгээний газар”, “Арвайхээр-Цэцэрлэгжилт” ОНӨААТҮГазар, “Хужирт-тохижилт үйлчилгээний газар”-ын дарга нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011101028


 Аймгийн Засаг даргын 2018 оны 07...
 дугаар сарын 30...-ны өдрийн А/НЗ... дүгээр
 захирамжийн хавсралт

“Арвайхээр-тохижилт үйлчилгээний газар”, “Арвайхээр-Цэцэрлэгжилт”,
 “Хужирт-тохижилт үйлчилгээний газар” орон нутгийн өмчит аж
 ахуйн тооцоот үйлдвэрийн газруудын бүтэц, орон тоог

“Хужирт-ТҮК”	Зохион байгуулагч	1
	Жолооч	2
	Ачигч	2
	Үйлчлэгч	1
Бүгд		6
“Арвайхээр-ТҮК”	Дарга	1
	Менежер	3
	Нягтлан бодогч	1
	Мэргэжилтэн	3
	Нярав	1
	Жолооч	14
	Зам талбайн үйлчлэгч	13
	Галч	4
	Ачигч	7
	Билет шалгагч	4
	Рейс бүртгэгч	2
	хаалгач	3
	Архив, бичиг хэргийн ажилтан	1
	цахилгаанчин	1
	Контор барилгын үйлчлэгч	1
	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн механик	1
	Оператор гагнуурчин	1
Оператор эксковаторчин	1	
Анчин	1	
Бүгд		63
“Арвайхээр-цэцэрлэгжилт”	Дарга	1
	Нягтлан бодогч	1
	Ногоон байгууламж хариуцсан мэргэжилтэн	1
	Цэцэрлэгч жолооч	1
	Наадмын талбайн сахиул	1
	ХЗПаркийн харуул	4
	Цэцэрлэгт хүрээлэнгийн харуул	4
	Цэцэрлэгжүүлэгч	3
	Билет шалгагч, тоглуулагч	6
Бүгд		22